



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 495

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 5,855,351,323.00 (таван тэрбум найман зуун тавин таван сая гурван зуун тавин нэгэн мянга гурван зуун хорин гурав) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Увс аймаг, Говь-Алтай аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатар, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Цогтсайхан, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Дашпунцаг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006876

37-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26 ны өдрийн
795 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН УВС АЙМАГ,
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (тегрөгөөр)	Улсын комиссын акт		Ашиглагч байгууллага
				огноо	дугаар	
1	Архивын барилга /Увс аймаг, Улаангом сум/	1200 м2 талбайтай /24.0*18.0 м хэмжээтэй зорьтой 2 давхар/ цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, караказ	2,856,555,323.00	8/8/2023	2023/88	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар
2	Төрийн архивын барилга /Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум/	1200 м2 талбайтай /24.0*18.0 м хэмжээтэй зорьтой 2 давхар/ цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, карказ	2,998,796,000.00	10/30/2023	2023/175	Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар
	Нийт дүн		5,855,351,323.00 (таван тэрбум найман зуун тавин таван сая гурван зуун тавин нэгэн мянга гурван зуун хорин гурав)			